



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жагсон Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [statelibrary@parliament.mn](mailto:statelibrary@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2025.01.23 № 04

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД С.ОДОНТУЯА  
ТАНАА

Тушаалын хэрэгжилтийн талаар  
асуулга тавих тухай

Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гэж, 8.1.14 дэх заалтад "үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах." гэж, 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй." гэж заасан.

Үүнийг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаартай "Жагсаалт батлах тухай" хамтарсан тушаалаар "үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт"-ыг баталж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагуудад мэдэгдэн, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг тус яамдад үүрэг болгосон байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн би нийт ард түмний элч, төлөөлөгч байх үүргийнхээ дагуу болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дээр дурьдсан хамтарсан тушаалаар батлагдсан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч аж ахуйн нэгж, байгууллага, компаниуд бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүргээ хэрхэн биелүүлж байгаа, дээрх үүргээ биелүүлж байгаа эсэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зүгээс хэрхэн хяналт тавьж байгаа талаар асуулга тавьж байна.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Н.НАРАНБААТАР

2025000901